

**ОҮИТБС-ын төрөлжсөн 3-р ажлын хэсгийн
хурлын тэмдэглэл**

Огноо: 2015 оны 3 дугаар сар 30, 15 цаг

Хурал болсон газар: Сангийн яам

Ирц: Ажлын хэсгийн ахлагч Б.Болормаа, гишүүд Г.Зулай, Д.Энхтуяа, П.Болормаа, Бат-Эрдэнэ, Г.Ганбат нарын бүрэлдэхүүнтэй буюу ажлын хэсгийн нийт 11 гишүүнээс 6 хүрэлцэн ирж, 54,5% ирцтэй хуралдав.

Хуралд иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл оролцоогүй бөгөөд дараа дараагийн хурал болон ажлын хэсгийн бусад үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг бүрэн оролцуулах хэрэгтэй байгаа талаар ажлын хэсгийн ахлагч болон компаний төлөөлөл анхааруулав.

Хурлыг ажлын хэсгийн ахлагч Сангийн яамны НББГ-ын ахлах мэргэжилтэн Б.Болормаа удирдан явуулав. Хуралд хүрэлцэн ирсэн гишүүд болон ажлын хэсгийн зорилго, хийх ажлын цар хүрээг нарийн бичиг Г.Ганбат танилцуулснаар хурал эхлэв.

Хэлэлцсэн асуудал 1. *ОҮИТБС-ын тайлангийн маягтыг дахин нягтлах, маягт бөглөх зааварчилгааг боловсронгуй болгох*

Хүн амын орлогын албан татварыг маягтад оруулах эсэх, ус бохирдуулсны төлбөр, мөнгөн бус хандив дэмжлэгийг хэрхэн тайлагнах зэрэг асуудлаар гишүүд саналаа илэрхийлэв.

ОҮИТБС-ын стандартад хүн амын орлогын албан татварын тухай хэрхэн тусгасан байдгийг нягтлах, тайлан гаргагч жижиг аж ахуйн нэгжүүдээс маягтыг бөглөхөд гарч буй хүндрэл, ойлгомжгүй зүйлс юу байдаг талаар судалгаа авах болов.

Ажлын хэсгийн бүх гишүүд ОҮИТБС-ын маягт болон түүнд оруулах шаардлагатай өөрчлөлтийн талаар саналаа 4-р сарын 10-ний дотор имэйлээр илгээх, Г.Ганбат ирсэн саналуудыг нэгтгэж боловсруулахаар тогтов.

Хэлэлцсэн асуудал 2. Засгийн газрын мэдээлэл цуглуулах процессыг нягтлах, мэдээллийн найдвартай байдлыг хангах

Энэхүү асуудлын томъёолол ерөнхий, шийдвэрлэх асуудал тодорхойгүй байгаа тул Ажлын хэсгийн өргөтгөсөн хурлын тэмдэглэлтэй дахин танилцах, тэмдэглэлийн холбогдох хэсгийг Г.Ганбат гишүүдэд имэйлээр илгээхээр тогтов

Хэлэлцсэн асуудал 3. Аудитын нэгтгэлээр гаргах өгөх нэмэлт мэдээллийн жагсаалт гаргах, түүнд тохирсон маягт боловсруулах, аудитын ажлын даалгаварт оруулах

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 12-р хуралдаанд энэ саналыг гаргасан Ашигт малтмалын газрын болон Улаанбаатар Аудит компаний төлөөлөл энэ удаагийн хуралд оролцоогүй тул тэдний саналыг имэйлээр тодорхой авах. Аудитын явцад шаарддаг мэдээллийн жагсаалтыг гаргаж, маягт боловсруулах шаардлагатай эсэхийг тодорхойлох. Шаардлагатай бол маягт боловсруулах, шаардлагагүй бол аудитын явцад гаргаж өгөх мэдээллийн минимум жагсаалтыг бий болгохоор тогтов.

Хэлэлцсэн асуудал 4. Компаниудын болон Засгийн газрын (Орон нутгийн болон төрийн захиргааны байгууллагын гаргадаг) ОУИТБС-ын тайланг аудитаар баталгаажуулах боломжийг судлах, зөвлөмж боловсруулах

Ажлын хэсэгт ажиллаж буй компаний төлөөллүүдийн зүгээс ОУИТБС нь нэгэнт тухайн компаний аудитаар баталгаажсан тайланд үндэслэж гардаг тул дахин аудитад оруулах хэрэггүй бөгөөд компанид нэмэлт зардал болох тул шаардлагагүй гэж үзэв.

Төрийн байгууллагуудын санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар баталгаажуулдаг боловч ОУИТБС-ын тайланг гаргахтай цаг хугацааны хувьд таардаггүй учир одоогоор боломжгүй гэж үзэв.

Мөн Төрийн аудитын тухай хууль, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд энэ талаар хэрхэн зохицуулахаар тусгасныг судлах, Үндэсний аудитын газарт Сангийн яамнаас албан бичгээр хандаж тодруулга авахаар тогтов.

Ажлын хэсгийн гишүүд дээрх хэлэлцсэн асуудлын хүрээнд ажиллаж, шаардлагатай мэдээллүүдийг цуглуулж, судалж, боловсруулан 4-р сарын 15-ны дотор саналаа илэрхийлэх бөгөөд дараагийн хурлын товыг жич зарлахаар тогтож энэ удаагийн хурал өндөрлөв.

Тэмдэглэл бичсэн: Ажлын хэсгийн нарийн бичиг Г.Ганбат